



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 468

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 1 дэх заалтад ““Дуудлагын худалдаа зохион байгуулсан тайлан”-ийн маягтыг 5 дугаар хавсралтаар” гэж нэмсүгэй.

2.“Дуудлагын худалдаа зохион байгуулсан тайлан”-ийн маягтыг тогтоолын хавсралтаар баталсугай.

3.Төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдсан үйл ажиллагааг энэ тогтоолоор баталсан маягтын дагуу тухай бүр (цаасаар болон цахимаар) тайлагнаж байхыг төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг орон нутгийн өмчийн харилцаанд жишиг болгож, холбогдох дүрэм, журамдаа өөрчлөлт оруулан мөрдөж ашиглахыг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

5.Тогтоолыг нийт төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Дэлгэрмаа)-т тус тус даалгасугай.


ДАРГА

ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.ДЭЛГЭРМАА



## ДУУДЛАГЫН ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЙЛАН

Хуулийн этгээдийн нэр: .....

Тайлагнах үзүүлэлт	Мэдээллийн хэмжих нэгж, агуулга	Хэрэгжсэн байдал /ТАЙЛБАР/
Дуудлагын худалдаа явуулах шийдвэр	Дугаар, огноо	*тухайлбал: ТӨБЗГ-ын 2023-09-26-ны тогтоол №156
Худалдсан хөрөнгийн мэдээлэл:	Хөрөнгийн нэр, (автомашин бол улсын дугаар)	*тухайлбал: Тээврийн хэрэгсэл Ланд-100, УБХ 2020
Ажлын хэсэг (комисс)	Томилсон тушаал	Тушаалын огноо, дугаар, хуулбарыг хавсаргах
Дуудлагын худалдааны зар мэдээ	ТӨБЗГ-ын 2019 оны 269-р тогтоолын 1-р хавсралтаар зарлан мэдээлснийг нотлох баримт, зардлын баримт	<ul style="list-style-type: none"> <li>Зар мэдээ гарсан Өдөр тутмын сонин хавсаргах</li> <li>Зар мэдээ байршуулах төлбөр төлсөн баримт хавсаргах</li> </ul>
Дуудлагын худалдааны тэмдэглэл, Худалдах, худалдан авах гэрээ	ТӨБЗГ-ын 2019 оны 269-р тогтоолын 3, 4-р хавсралт	<ul style="list-style-type: none"> <li>Дуудлагын худалдааг зохион байгуулсан тэмдэглэлийг маягтын дагуу хөтөлж, гарын үсгээр баталгаажуулж хавсаргах</li> <li>Худалдах, худалдан авах гэрээ байгуулж баталгаажуулсан, хэрэгжүүлсэн байх, хуулбарыг хавсаргах</li> </ul>
Дуудлагын худалдаа болсон хугацаа	Товлосон хугацаанд	20.. оны ...дугаар сарын ... -ны өдрийн .... цагт
Дуудлагын худалдаа болсон газар	Зар мэдээний дагуух хаяг, байршил	.....
Худалдах доод үнэ	ТӨБЗГ-ын тогтоолоор баталсан	Доод үнэ .....(тоогоор) ..... (үсгээр) төгрөг
Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ	ТӨБЗГ-ын 2019 оны 268-р тогтоолын 1 дүгээр заалтаар	Худалдах доод үнийн ..... хувь буюу ..... (тоогоор) ..... (үсгээр) төгрөг
Худалдсан үнэ	Үнэ хаялцан тогтсон хамгийн дээд үнэ	Худалдсан үнэ .....(тоогоор) ..... (үсгээр) төгрөг
Дуудлагын худалдааны ялагч	Иргэн, хуулийн этгээд	.....(Үнэ хаялцан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд)
ТӨБЗГ-ын улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн хөрөнгийн орлогын дүн	Төгрөгөөр, нотлох баримт	<ul style="list-style-type: none"> <li>.....(тоогоор) ..... (үсгээр) төгрөг</li> <li>Нотлох төлбөрийн баримтыг хавсаргах.</li> </ul>

Дуудлагын худалдааг зохион байгуулсан Ажлын хэсэг:

Ахлагч: .....

Гишүүд: .....